

уголовно-правового запрета, отличных от функций нормы права (нормы уголовного права) и функций состава преступления, обусловлено спецификой его правовой природы как сложного социально-правового феномена. Уголовно-правовой запрет выполняет различные функции на разных уровнях действия уголовного права.

Таким образом, развитие теории уголовно-правового запрета представляет интерес и с позиции общедемократического развития государства и общества, она позволит «уйти» от классического системно-структурного («нормативного») и карательного («наказательного») подходов в понимании уголовного права как совокупности норм права.



**Горкина Светлана
Александровна**

ОХУ-ын Ял эдлүүлэх албаны Академийн Ял эдлүүлэх тогтолцооны удирдлага, үйл ажиллагааны зохион байгуулалтын

тэнхимийн орлогч дарга, хууль зүйн шинжлэх ухааны дэд доктор, доцент

Подьяблонский Павел Александрович
ОХУ-ын Ял эдлүүлэх албаны Академийн ял эдлүүлэх тогтолцооны удирдлага, үйл ажиллагааны зохион байгуулалтын тэнхимийн ахлах багш, хууль зүйн шинжлэх ухааны дэд доктор

**ПЕРЕПРОФИЛИРОВАНИЕ
ВОСПИТАТЕЛЬНЫХ КОЛОНИЙ В
ВОСПИТАТЕЛЬНЫЕ ЦЕНТРЫ ДЛЯ
НЕСОВЕРШЕННОЛЕТНИХ ЛИЦ
ЖЕНСКОГО ПОЛА НА СОВРЕМЕННОМ
ЭТАПЕ РАЗВИТИЯ УГОЛОВНО-
ИСПОЛНИТЕЛЬНОЙ СИСТЕМЫ:
ПРОБЛЕМЫ И ПЕРСПЕКТИВЫ**

ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ТОГТОЛЦООНЫ
ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН ШАТАНД
ХҮМҮҮЖҮҮЛЭХ ХОРИХ АНГИЙГ
НАСАНД ХҮРЭЭГҮЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ
ХҮМҮҮЖҮҮЛЭХ ТӨВ БОЛГОН ӨӨРЧЛӨН
ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ: АСУУДАЛ БА
ХЭТИЙН ТӨЛӨВ

Товч агуулга: Тус илтгэлд жирийн болон чанга дэглэмтэй хүмүүжүүлэх төвийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтцийг санал болгож хүмүүжүүлэх хорих ангийг хүмүүжүүлэх төв болгон өөрчлөх асуудлууд, насанд хүрээгүй этгээдийн ял эдлэх эрх зүйн зохицуулалтыг авч үзсэн.

Ключевые слова: исполнение наказания; несовершеннолетние лица женского пола; воспитательный центр; помещение, функционирующее в режиме следственного изолятора; социально-

реабилитационный центр для подготовки осужденных к освобождению, организационная структура управления, функциональная структура управления, организация режима и надзора.

Түлхүүр үгнүүд: ял эдлүүлэх, насанд хүрээгүй эмэгтэй, хүмүүжүүлэх төв, цагдан хорих байрны зориулалтаар ашиглагдаж буй байр, ялтныг суллахад бэлтгэдэг нийгэмшүүлэх төв, удирдлагын зохион байгуулалтын бүтэц, удирдлагын үйл ажиллагааны бүтэц, хяналт ба дэглэмийн зохион байгуулалт.

В современных условиях жизни и развития общества резко обострились проблемы обеспечения законности и правопорядка. Негативные тенденции не обошли стороной и одну из самых многочисленных и наиболее уязвимых в социальном плане групп населения – молодежь. У несовершеннолетних оказались ослабленными связи с такими социальными институтами общества и государства, как семья, школа, трудовой коллектив. Эти и другие факторы обусловили рост преступной активности несовершеннолетних, что, естественно, вызывает тревогу, так как под угрозой оказывается физическое и нравственное здоровье подрастающего поколения.

Преступность несовершеннолетних лиц женского пола, имея относительно постоянную величину в структуре преступности несовершеннолетних и общей преступности, представляет собой явление, изменяющееся в соответствии с реальными условиями.

Последнее десятилетие стало периодом кардинальных изменений в российском обществе и государстве. В соответствии с Концепцией развития уголовно-исполнительной системы Российской Федерации до 2020 г. воспитательные колонии преобразуются в воспитательные центры.

На 2013 год функционируют 45 воспитательных колоний (ВК), из которых для несовершеннолетних лиц женского пола 2 воспитательные колонии, в дальнейшем предполагается создание 33 воспитательных центров двух видов: с обычным наблюдением (для несовершеннолетних, впервые осужденных к лишению свободы) и с усиленным наблюдением (для несовершеннолетних, ранее отбывавших наказание в виде лишения свободы). Каждый воспитательный центр будет включать в себя четыре основных структурных элемента: участок для содержания несовершеннолетних осужденных, достигших 18 лет; помещение, функционирующее в режиме следственного изолятора, для несовершеннолетних правонарушителей – ПФРСИ); социально-реабилитационный центр для подготовки осужденных к освобождению. При этом, учитывая, что доля несовершеннолетних женского пола, осужденных к лишению свободы, относительно постоянна и составляет около 8 %, предлагается выделение трех воспитательных центров для данной категории лиц.

Предлагается следующая функциональная и организационная структура ВЦ с обычным и усиленным наблюдением:

1. Помещение, функционирующее в режиме следственного изолятора (ПФРСИ). Здесь находятся несовершеннолетние подследственные обвиняемые и осужденные, в отношении которых приговор суда не вступил в законную силу;

2. Изолированный участок для содержания лиц, осужденных за совершение особо тяжких преступлений, лиц, совершивших преступления во время отбывания наказания, а также ранее отбывавших наказание в виде

лишения свободы (предполагается обеспечение усиленного наблюдения);

3. Участок для содержания остальных категорий осужденных к лишению свободы за преступления, совершенные в несовершеннолетнем возрасте (предполагается обеспечение обычного наблюдения);

4. Участок для содержания совершеннолетних осужденных, достигших 19-летнего возраста, до момента их освобождения от наказания (обычное наблюдение);

5. Изолированный участок для содержания осужденных, достигших совершеннолетия - нарушителей режима отбывания наказания и не желающих исправляться (усиленное наблюдение).

6. Реабилитационный участок, располагаемый за пределами ВЦ. Здесь осужденные находятся без охраны, но под надзором. Этот участок предполагается для эффективной работы по подготовке осужденных к освобождению.

При организации режима и надзора в помещении, функционирующем в режиме следственного изолятора (ПФРСИ), где находятся несовершеннолетние подсудимые обвиняемые и осужденные, в отношении которых приговор суда не вступил в законную силу, необходимо руководствоваться Приказом Минюста РФ «Об утверждении Инструкции об организации службы по обеспечению надзора за подозреваемыми, обвиняемыми и осужденными, содержащимися в следственных изоляторах и тюрьмах уголовно-исполнительной системы» и Приказом Минюста РФ от 14 октября 2005 года № 189 «Об утверждении Правил внутреннего распорядка следственных

изоляторов уголовно-исполнительной системы».

При предлагаемой модели ВЦ в помещении ДИЗО предусмотреть раздельное покамерное размещение следующих категорий:

1. размещение лиц, содержащихся в помещении, функционирующем в режиме следственного изолятора (ПФРСИ), где находятся несовершеннолетние подсудимые обвиняемые и осужденные, в отношении которых приговор суда не вступил в законную силу;

2. содержания нарушителей установленного порядка отбывания наказания с обычным наблюдением;

3. содержания нарушителей установленного порядка отбывания наказания с усиленным наблюдением (при размещении в ВЦ участка с усиленным наблюдением);

4. содержание лиц из числа нарушителей режима переведенных в соответствии с решением суда в тюрьму общего режима.

Отличия воспитательного центра от воспитательной колонии:

- создание структуры воспитательного центра, позволяющей обеспечить непрерывность и преемственность социальной, психологической и воспитательной работы с несовершеннолетними с момента заключения под стражу и до момента освобождения, посредством включения в него ПФРСИ; участка для содержания несовершеннолетних осужденных, а также положительно характеризующихся осужденных в возрасте до 19 лет; изолированного участка, функционирующего в режиме

ИК (тюрьмы) общего режима; социально-реабилитационного центра;

- обеспечение отдельного содержания осужденных, имеющих наибольшую степень криминальной зараженности сознания, от остальной части воспитанников (ВЦ с обычным и усиленным наблюдением; наличие локальных изолированных участков внутри ВЦ);

- обеспечение приоритета в работе психолого-педагогических и социальных методов и форм воздействия на осужденных;

- наличие в штатах воспитательного центра большого удельного веса сотрудников, осуществляющих функции социальной, психологической и воспитательной работы с осужденными, а также функции медицинского обслуживания (с одновременной их специализацией в зависимости от категорий осужденных, участка воспитательного дома, этапа отбывания наказания);

- наличие в структуре воспитательного центра социально-реабилитационного центра, позволяющего повысить эффективность подготовки осужденных к освобождению, их ресоциализации;

- минимизация в работе воспитательных центров элементов, характерных для тюремного учреждения;

- оптимизация численности несовершеннолетних осужденных в коллективах, создание мультидисциплинарных групп осужденных (вместо отрядов), позволяющих обеспечить индивидуализацию процесса исправительного воздействия;

- специализированная подготовка основных категорий сотрудников по работе с несовершеннолетними осужденными, в том числе на базе высших образовательных учреждений ФСИН России.

В основе содержания Концепции, предполагающей создание учреждений нового типа для несовершеннолетних, заключенных под стражу и осужденных к лишению свободы, – признанные Российской Федерацией правовые стандарты Совета Европы: Концепция о защите прав человека и основных свобод, Европейские пенитенциарные правила, прецедентные решения Европейского Суда по правам человека, а также рекомендации Европейского комитета по предупреждению пыток и бесчеловечного или унижающего достоинство обращения или наказания, стандарты в обращении с заключенными, принятые ООН.

В настоящее время криминологический портрет несовершеннолетнего осужденного представляет собой 16–17-летнего подростка, ранее не работавшего и не учившегося, с отклонениями в психическом развитии, имеющего условную судимость или отсрочку приговора, осужденного за тяжкие либо особо тяжкие преступления.

Лица, совершившие преступления в несовершеннолетнем возрасте, в силу возрастной и социальной незрелости составляют особую группу осужденных из числа отбывающих наказание в местах лишения свободы. Особенности подросткового возраста в определенной мере осложняют воспитательную работу с ними, требуют от персонала ВК учета «взрывоопасности» и импульсивности воспитанников. Во многом именно этими обстоятельствами объясняется обострение оперативной обстановки в некоторых ВК и ростом количества преступлений,

совершенных несовершеннолетними осужденными.

Вопросы организации деятельности воспитательных колоний в современных условиях находятся под пристальным вниманием всех ветвей власти Российской Федерации, руководства ФСИН России, общественных и правозащитных организаций. Указанием директора ФСИН России кураторство воспитательных колоний субъектов Российской Федерации возложено лично на руководителей территориальных органов. Это подтверждает необходимость организации деятельности всех служб данных учреждений на основе строгого соблюдения законности при исполнении наказаний в виде лишения свободы в отношении несовершеннолетних, совершенствования форм и методов воспитательной работы, социального и психологического сопровождения.

По состоянию за 2013 г. в ВК содержалось 1983 человека, в том числе в несовершеннолетних лиц женского пола – 110. В большинстве ВК криминогенная обстановка остается достаточно сложной. Так, в 2013 г. в воспитательных колониях было допущено нарушений установленного порядка отбывания наказаний 2159, из которых последовало водворение в дисциплинарный изолятор 871 чел. Всего в ВК в 2013 г. было предотвращено 1058 преступлений, что составило нарушений установленного порядка отбывания наказаний (на 1000 человек) – 1088,7.

Лица, осужденные в несовершеннолетнем возрасте, освобождаются из мест лишения свободы в активном возрасте, позволяющем социально определиться и закрепиться в обществе: продолжить учебу, трудоустроиться и завести семью. Для этого необходимо обеспечить: отбывание наказания несовершеннолетними

осужденными в пределах территории субъекта Российской Федерации, в котором они проживали до осуждения; развитие института попечительских советов при воспитательных колониях (центрах); развитие института родительских комитетов воспитательных колоний (центров); широкий доступ в воспитательные колонии организациям, обеспечивающим подготовку осужденных к освобождению (их трудовую занятость и социально-бытовое устройство).



Г.БАТТУЛГА

Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Аюулгүй
байдлын тэнхимийн
ахлах багш, хошууч

ПЕНИТЕНЦИАР КРИМИНОЛОГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ.

Пенитенциар криминологи гэж юу вэ? Пенитенциар криминологи нь өөрийн гэсэн судалгааны объекттой, үүсэл хөгжлийн зүй тогтолтой криминологийн шинжлэх ухааны бие даасан салбар мөн үү? гэх мэт олон асуултыг энэ салбарын судлаачид, криминологчид өөрсдөдөө болон өөр хоорондоо тавьдаг. Гэсэн хэдий ч “Пенитенциарной криминологии” “Penitentiary/Prisons Criminology” хэмээн нэрлэгдэж нэгэнтээ олон оронд хэрэглэгдэж байгаа томъёолол бөгөөд манай оронд ч “Пенитенциар криминологи” “Пенитенциар гэмт явдал” хэмээх нэр томъёо хэрэглэгдэх болжээ.

Пенитенциар криминологийн үүсэл хөгжлийн талаар зөв ойлголттой болохын тулд ял шийтгэл, түүний үүсэн хөгжиж ирсэн түүхийг авч үзэх нь зүйтэй.

Хүн төрөлхтөний түүхэнд төр үүсч бий болсон цагаас гэмт этгээдэд ял шийтгэл оногдуулж байсан бөгөөд энэ хатуу ширүүн ял шийтгэлийн төрөл бүхий хэм хэмжээгээр зохицуулагдаж байжээ. Нийгмийн харилцаа боловсронгуй болох тусам төрийн хууль, тогтоомж түүний үйлчлэх хүрээ тодорхой /хязгаартай/ болж нийгмийн амьдралыг тогтвортой хэвийн хэмжээнд байлгахад чиглэгдэх болов.

XVIII зууны үеэс хүний эрхийг хүндэтгэх, шудрага энэрэнгүй ёсны зарчимд тулгуурласан ял шийтгэл

үйлчилж эхлэсэн бөгөөд энэ нь тухайн үеийн нэрт соён гэгээрүүлэгчдийн бүтээл, онол сургаалиудад тусгалаа олсон байдаг. Тухайлбал Францын сэтгэгч Вольтер: “Ялын зорилго нь айлган сүрдүүлэх, урьдчилан сэргийлэхэд оршино. Төр яллахыг урьтал болгохоос яаж урьдчилан сэргийлэх вэ гэдгийг бодож олох ёстой” гэжээ. Мөн Ч. Беккариа “Гэмт хэрэг ба ял” зохиолдоо үйлдсэн гэмт хэрэг, хүлээлгэх ял хоёр тохирч байх ёстой. Ялын зорилго нь “хүнийг зовооход бус, гэмт этгээдийг нийгэмд дахин хор хөнөөл учруулахаас болон бусдыг гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулахад оршино” хэмээжээ. Энэхүү үзэл сургаалийг дэмжигчид ялтныг хүмүүжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэхэд *шорон* үр ашигтай хэрэгсэл болно гэж үзэж байв.

Шоронд хорин эрх чөлөөг хасах явдал нь ялын бусад хэлбэрүүдийг бодвол нилээд сүүлд бүрдсэн эрүүгийн ял шийтгэлийн төрөл бөгөөд энэ нь тухайн үедээ гэмт этгээдэд илүү хүнлэг энэрэнгүй хандаж буй хэлбэр гэж үзэж байлаа. Хорих ял нь нэг талаас хорих ял эдлэгсдийг ажил хөдөлмөр эрхлүүлэх, нөгөө талаас гэмт этгээдийг хийсэн гэмт үйлдлээ гэмших нөхцөл бүрдүүлэн дахин гэмт хэрэг өдүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгыг агуулж байснаараа тухайн үеийн бусад ял шийтгэлийн төрлүүдээс шинэлэг байжээ.

Хорих ялыг эрүүгийн ялын нэгэн төрөл болгон хэрэглэсэн үеэс энэхүү шинээр үүсэж буй харилцааг тодорхой хэм хэмжээ, хууль, журмуудаар зохицуулах хэрэгцээ зүй ёсоор урган гарсан. Хорих ял эдлүүлэх харилцааг зохицуулж байсан анхны хэм хэмжээнүүд нь юуны өмнө тухайн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхгүй байхад чиглэсэн нөлөөлөл үзүүдэх явдлаар тодорхойлогдож байлаа. Тухайн үеийн шорон гяндангийн системд шинэчлэл

хийхэд нөлөөлсөн томоохон судлаач бол Джон Говард юм.

Тэрээр Оросын болон Европын орнуудын шорон, гяндангаар явж харьцуулан судалгаа хийсний эцэст 1780 онд “Шоронгуудын нөхцөл байдал” гэсэн бүтээл тууриг бөгөөд уг бүтээлээрээ хорих ял эдлүүлэх ажиллагааны онолын асуудлуудыг анх гаргаж тавьсан байна. Джон Говард судалгааныхаа үр дүнд “хорих газарт хүнийг бүх насаар нь хорих явдал нь тухайн хүнийг ёс суртахуун, оюун санаа болон бие бялдрын хувьд ихээхэн доройтуулж байгаа хэрэг юм. Иймд бүх насаар нь хорих ялыг халах, шорон гяндангуудад хөдөлмөр эрхлэлтийг өргөн хэрэгжүүлэх, хоригдогсдын хөдөлмөрт дуртай, идэвхтэй хандаж буй хэсгийг нь хугацаанаас нь өмнө суллах, ганцаарчлан хорьж”⁵⁵ байхыг санал болгожээ. Энэхүү үзэл санаа нь хорих ял эдлүүлэх системд шинэ ойлголтыг бий болгож эрүүгийн ялын хэрэгжилтэнд томоохон нөлөөлөл үзүүлсэн гэж үздэг.

Эдгээр үзэл санаанаас улбаатайгаар хууль тогтоогчдын дунд ч ял шийтгэл нь гэмт хэрэгтний оюун санаа, ёс суртахуун бие мах бодь, эрүүл мэндэд хор хохирол учруулахгүй байх, тэднийг засарч хүмүүжих бололцоог олгоход чиглэх ёстой гэсэн үзэл баримтлал тогтож эхлэсэн байна.

XVIII зууны эцсээр АНУ-д “Нью-Йоркийн шоронгийн нийгэмлэг” байгуулагдан их дээд сургуулиудад шорон судлах тэнхимүүд нээгдэж, Европын улсуудын засгийн газрууд болон АНУ ихээхэн зардал гарган шоронгийн тогтолцоогоо шинэчлэсэн. Анх 1786 онд Филадельфи, Пенсильвани мужид ганцаар хорих шоронг байгуулж

“Пенитенциар” буюу Penitentiary⁵⁶ /paenitentia - гэмшил гэсэн латин үгнээс гарвалтай/ гэсэн нэрийг авч улмаар мэдлэгийн шинэ салбар үүсэн бий болж, түүний судлах зүйл нь шоронгийн үйл ажиллагааны практик болсон юм⁵⁷. Гэсэн хэдий ч ганцаарчлан хорих энэ систем нь тухайн үед нэлээд эсэргүүцэлтэй тулгарч байсан бөгөөд үүнээс үүдэлтэйгээр Нью-Йорк мужын Оборн хотод шоронгийн шинэ систем бий болж үүнийг Оборны систем гэх болсон байна. Энэ нь ялтныг ганцаарчилж хорих боловч өдрийн цагаар хөдөлмөрлүүлж, цалин олгох ялтнуудыг хамтын хөдөлмөрт сургах, хүмүүжүүлэхэд гол онцлог нь оршиж байв.

Америкийн энэ систем нь Европт дэлгэрч XIX зууны дунд үеэс уг тогтолцоог дэлхийн олон улс орон өөр өөрийн онцлогт тохируулан хэрэглэх болжээ. Үүний нэг жишээ нь Англи-Ирландын дэвшилтэт систем бөгөөд энэ систем нь ялтнуудын зан байдал, хөдөлмөрт хандах хандлага, хүмүүжил зэргийг нь харгалзан тодорхой үе шатуудад ял эдлүүлж засрал хүмүүжлийг нь оноогоор дүгнэн суллагдах боломж олгодог байв. Хорих ял эдлүүлэх тогтолцоо боловсронгуй болохын хэрээр дэлхийн улс орнууд өөрсдийн онцлогт тохируулан хэрэглэх болсон байна. Тухайлбал Орос оронд Англи-Ирландын систем нилээд дэлгэрч улмаар 1924 онд ял эдлүүлэх хуулиндаа эл тогтолцоог баталгаажуулжээ⁵⁸.

Ийнхүү хорих ялыг өргөн хэрэглэх болсноор эерэг сөрөг үр дагавар ихээхэн гарах болж үүнийг шийдвэрлэх

⁵⁵ И.А. Уванов., Введение в пенитенциарную криминологию. Москва 2007 г. Стр 9.

⁵⁶ Penitentiary нь англиар засан хүмүүжүүлэх газар буюу дундад зууны үеийн сүм хийдэд папын шүүн таслах газарыг paenitentarius хэмээн нэрлэж байв.


⁵⁷ Р. Оюунбадам, Д.Бадам. Хорих ял эдлүүлэх дэглэмийн эх зүйн зохицуулалт. УБ. 2005 он. 8 дах тал

⁵⁸ Р. Оюунбадам, Д.Бадам. Дурдсан зохиол. 10 дах тал

үүднээс гэмт хэрэгтнийг засан хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх зорилго бүхий *Пенологи* гэсэн шинжлэх ухаан үүсэн бий болсон байна. Пенологи нь ял эдлүүлэх тухай сургаалиудаас үүсэлтэй криминологийн шинжлэх ухааны тусгай судлагдахуун бөгөөд ялын үр ашигтай санцрыг шинжлэх ухаан практикийн үндсэн дээр боловсруулахад чиглэсэн ял шийтгэлийн тухай тусгайлан авч судладаг бие даасан шинжлэх ухаан юм⁵⁹. Мөн хорих ялыг өргөн хэрэглэснээр нийгмийн тодорхой бүлэг, хэсэг бүрэлдэн бий болсон нь *Ялан* буюу *Хоригдлууд* юм. Нийгмийн энэхүү бүлгийг ОХУ-н зарим судлаачид а) төрөөс хорих ялаар шийтгүүлэн шоронд хоригдож буй нийт ял эдлэгсэд буюу *албан бүлэг* б) хорих ял эдлэх явцдаа хүсэл, сонирхол, хэрэгцээгээрээ өөр хоорондоо сайн дураараа нэгдсэн *албан бус* бүлэг /хамт олон/ гэж үндсэн хоёр хэсэгт хуваан авч үзсэн байдаг. Эдгээр шинээр бий болсон нийгмийн бүлгийг социологийн талаас нь судлах явдал нь *Пенитенциар социологи* хэмээх мэдлэгийн бие даасан салбарыг үүсгэхэд хүргэжээ⁶⁰.

Хорих буюу засан хүмүүжүүлэх байгууллагууд нь хаалттай, хязгаарлагдмал, нутаг дэвсгэрийн байдлаар бүрэлдэн тогтсон байдгаас гадна тэнд хоригдогсод нь хууль зөрчсөний улмаас эрүүгийн ял шийтгэл хүлээн ял эдлэж буй ялтнууд байдаг бөгөөд ял эдлүүлэх, ялтныг засан хүмүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж буй ажилтан албан хаагчид болон ялтнуудын хооронд өвөрмөц харилцаа үүсэж байдаг. Хорих байгууллагуудын эдгээр өмөрмөц байдал, хорих ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх явцад бий болсон нийгмийн бүлэг *албан ба албан бус* зэргээс хамааран хорих

байгууллагын дотор үйлдэгддэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл ч мөн өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой юм. Ер нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл ногдуулж байгаа нь түүнийг хүмүүжүүлэх болон дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгод чиглэддэг. Тэгвэл хорих ангид гарч буй гэмт явдал, түүний хор уршиг, ялтан бие хүн болон гэмт бие хүн, тэдний онцлог байдал, рецидив гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам зэргийг криминологийн шинжлэх ухааны ололтод тулгуурлан тусгайлан судлаж тодорхойлох шаардлага зүй ёсоор урган гардаг. Чухам эдгээр онцлог чанар нь “салбар дундын криминологи”⁶¹ буюу *Пенитенциар криминологи* үүсэн бий болох нөхцөл бүрдүүлсэн гэж үзэх талтай. Үүнийг бүдүүвч маягаар авч үзвэл.



Бүдүүвч. 1. Пенитенциар криминологи үүссэн үе шатууд

Аливаа шинжлэх ухааны судлах зүйл, зорилго нь тухайн салбарын практик үйл ажиллагааг онолын үндэслэлтэй судлан тодорхойлж урагшлуулж байдаг зүй тогтолтой. Пенитенциар криминологийг ерөнхий криминологийн хүрээнд тодорхойлон авч үзвэл хорих газар гарч буй гэмт явдал, түүний хор уршиг, шалтгаан нөхцөл, гэмт хэрэгтэн болон хохирогч бие хүн, тэдний онцлог байдал, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааг криминологийн

⁵⁹ С. Нарангэрэл. Эрх зүйн эх толь. УБ. 2009.....

⁶⁰ И.А. Уванов., Введение в пенитенциарную криминологию. Москва 2007 г. Стр 15.

⁶¹ Г.Эрдэнэбат, Б.Батзориг, Г.Туяа. *Криминологи*. УБ. 2013 он. 19 дэх тал

шинжлэх ухааны ололтод тулгуурлан судлаж хорих газарт гардаг гэмт явдал болон рецидив гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга ажиллагааг боловсруулах арга замыг тодорхойлдог “салбар дундын криминологи” хэмээн авч үзэж болохоор байна

Бүдүүвч 2. Пенитенциар криминологийн судлах зүйлийн тодотгол⁶²



Нөгөө талаасаа зөвхөн хорих газар үйлдэгддэг гэмт хэргээс гадна нийгэмд үйлдэгддэг аливаа гэмт явдлын шалтгаан нөхцөл түүнийг үйлдэгч гэмт бие хүний зан төлөвт болон хорих ял эдлэгсдийн дунд бодитой, удаан хугацаанд, тогтвортой судалгаа хийх нөхцөл, бололцоо бий болдог. Энэ нь пенитенциар криминологийн судалгааны нэгэн чухал объект болж үүгээрээ ерөнхий криминологийн салбарын хөгжилд тодорхой түлхэц үзүүлж байдаг. Тухайлбал сүүлийн жилүүдэд гарч буй тоон үзүүлэлтээр манай дэлхий дээр 10 сая орчим хүн хорих ял эдлэж⁶³ байгаа бөгөөд энэ тоо үргэлж өсч байгаа нь сэтгэл түгшээсэн асуудлын нэг болоод байгаа билээ. Тэгвэл энэ тоог хэрхэн бууруулах вэ? гэдэг асуудал криминологийн шинжлэх ухаан,

криминологичдийн яах аргагүй анхаарлыг татах болжээ.

Олон улсын хүний эрхийн байгууллагаас гаргасан сүүлийн үеийн

судалгаагаар манай оронд 6772 хүн хорих ял эдлэж байгаагаас 3373 ялтан буюу 49.8 % нь анх удаа гэмт хэрэг үйлдэгсэд, 3399 ялтан буюу 50.2% нь дахин гэмт хэрэг үйлдсэн⁶⁴ рецидив гэмт хэрэгтнүүд хоригдож байгаагаас үзвэл рецидив гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлан, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ төдийл сайн хийгдэхгүй байгаа нь харагдаж байна. Пенитенциар криминологийн зайлшгүй судлах зүйлийн нэг нь рецидив гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлан тогтоох, рецидив гэмт хэрэгтний хувийн онцлогийг тодорхойлох замаар хорих ял эдлэж буй ялтнуудаас гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхэд явдал юм.

Мөн ялтныг нийгэмшүүлэх, засрал хүмүүжил олгоход хорих байгууллага нь бусад төр олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран үр дүнтэй арга тактикийг боловсруулах, тэднийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанд Криминологийн шинжлэх ухааны мэдлэгийг ашиглах зайлшгүй шаардлага гарч байна.

Бичсэн сэдвийн хүрээнд та бүхнээс ирүүлэх аливаа санал, шүүмжлэлийг судлаачийн зүгээс талархан хүлээн авах болно.

email: battulga.g@leu.gov.mn

⁶² И.А. Уванов., Введение в пенитенциарную кримиологию. Москва 2007 г. Стр 16.

⁶³ <http://news.bbc.co.uk/2/shared/spl/hi/uk/06/prisons/html/nn2page1.stm>

⁶⁴ Caritas Czech Republic., *Present conditions of human rights in Mongolian prisons. /Survey report/* Ulaanbaatar 2014, 17